



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/202


Улаанбаатар хот

### Ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, ШУТИС-ийн дүрмийн 4.14.10, 10.2, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал (Д.Цолмонбаатар), Ахисан түвшний хөтөлбөрийн албаны дарга (Д.Оюунцэцэг) нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулсан ШУТИС-ийн Ректорын 2008 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн “Магистрантын шилжилт хөдөлгөөний журам”, “Докторантын шилжилт хөдөлгөөний журам”, ШУТИС-ийн Ректорын 2011 оны А/63 дугаар тушаалаар батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн их сургуульд магистр, докторын сургалт эрхлэх, зэрэг хамгаалуулахад баримтлах журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалыг 2023-2024 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Т.НАМНАН

367040968